



**БАГАНУУР ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Д.Нацагдоржийн талбай, Наран хороолол,
1 дүгээр хороо, Багануур дүүрэг,
Улаанбаатар хот, 12090

Утас/Факс: (976) 7021 0017, 7021 0330

Цахим шуудан: info@bnd.ub.gov.mn

Цахим хаяг: www.bnd.ub.gov.mn

2026.08.07

№

04/880

танай

-ны №

-т

**БАГАНУУР ДҮҮРГИЙН 50
БАЙГУУЛЛАГАД**

Цөлжилттэй тэмцэх тухай Нэгдсэн үндэстний
байгууллагын конвенцын талуудын 17 дугаар бага
хурлыг 2026 оны 08 дугаар сарын 17-28-ны өдрүүдэд
Монгол Улсад зохион байгуулахтай холбогдуулан
байгууллагын ажилтан, албан хаагчдаа оролцуулж,
танилцуулах ажлыг зохион байгуулна уу.

Хавсралт 2 хуудастай.



Багануур дүүргийн засаг даргын тамгын газар
Удирдлага
Засаг даргын тамгын газрын дарга
Пүрэвдоо Баттүшиг
2026.08.07 10:34

1226110547



**ЦӨЛЖИЛТТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ
НҮБ-ЫН КОНВЕНЦЫН ТАЛУУДЫН
17 ДУГААР БАГА ХУРЛЫГ ЗОХИОН
БАЙГУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ
АЖЛЫН АЛБА**

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
4-р хороо, Анкарагийн гудамж-23, Tod Tower 301 тоот

Утас: 77003773

2026.07.30 № 26/12.

танай _____-ны № _____-т

Оролцоог хангах тухай

Цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын конвенцын Талуудын 17 дугаар бага хурлыг 2026 оны 8 дугаар сарын 17–28-ны өдрүүдэд Монгол Улсад зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Үндэсний хорооны дэргэдэх Ажлын алба хамтран Талуудын бага хурлын цэнхэр, ногоон бүсийн арга хэмжээний хөтөлбөр, цэнхэр бүсийн Монгол Улсын өргөө болон павьлионы нэгдсэн төлөвлөгөөний төсөл олон нийтэд албан ёсоор зарлагдахад бэлэн боллоо.

Талуудын 17 дугаар бага хурлыг хүлээн авч зохион байгуулж буй улсын төрийн байгууллагууд цэнхэр болон ногоон бүсийн төлөвлөлтөд тусгагдсан хаалттайгаас бусад арга хэмжээ, үйл ажиллагаануудад боломжит байдлаар байр суурь, саналаа илэрхийлэн оролцох боломжтой. Хэлэлцүүлэг, зэрэгцээ арга хэмжээ, үйл ажиллагаануудад оролцохдоо Монгол Улсын Засгийн газраас дэвшүүлж буй “Тал хээрийн төлөвлөгөө”-ний үндсэн чиглэлтэй уялдуулсан үйл ажиллагаа явуулах шаардлагатайг онцольё.

Тус бага хурлын барилга байгууламж, бүртгэл хийлгэх заавар бүхий ерөнхий танилцуулга; Тал хээрийн төлөвлөгөөний танилцуулга, цэнхэр бүсэд зохион байгуулагдах зэрэгцээ арга хэмжээний урьдчилсан төлөвлөгөө, ногоон бүсийн хөтөлбөр, Сайд нарын түвшний сэдэвчилсэн өдрүүдийн төлөвлөлтийн төслийг хавсралтаар хүргүүлж байна.

Иймд дээрх танилцуулга, мэдээллийг өөрийн эрхэлсэн асуудалд шууд хамаарах газар, агентлаг, харьяа байгууллагууддаа түгээн, бэлтгэлийг хангуулан, Талуудын бага хурлаас Монгол Улсад үлдэх өгөөж, үр дүнг нэмэгдүүлэхэд хамтран ажиллахыг хүсье.

Хавсралт 1 хуудастай.

Хүндэтгэсэн,

ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА БӨГӨӨД,
БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД

Ц.САНДАГ-ОЧИР

Хавсралт: Заавар болон танилцууга руу нэвтрэх QR.

